

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

8-Р САРЫН 18, 2020

Эдийн засгийн судалгааны алба

Эдийн засаг 2 улирал дарааллан хүчтэй уналаа. 2020 оны хагас жилийн байдлаар коронавирусийн нөлөөгөөр 10.7 хувиар буураад байсан эдийн засгийн голлох үзүүлэлт дахин 9.7 хувиар буурсныг ҮСХ-оос мэдээллээ. Эдийн засаг агшихад уул уурхайн салбарын 29.4 хувь, үйлчилгээний салбарын 8.2 хувийн бууралт нөлөөлжээ. Харин хөдөө аж ахуйн салбарт Коронавирус хамгийн бага нөлөөлж 13.2 хувиар өсчээ.

Төсвийн тодотгол хийж, 4.8 их наядын алдагдалтай төсвийн төсөөлөл өргөн барилаа. 2020 оны 7-р сарын байдлаар улсын төсвийн зардал 34.5 хувиар нэмэгдэж төсвийн орлого 18 хувиар буурсан байна. Ийнхүү төсвийн тэнцэл 2.5 их наяд төгрөгийн алдагдалтай байна. Цаашид энэ байдал илүү хурцадмал болохоор ажиглагдаж байна. Учир нь Ковид-19-тэй холбоотойгоор улсын төсвийн тодотгол энэ сард хийгдсэн ба оны эцсээр тэнцэвржүүлсэн тэнцэл нийт 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай гарахаар батлагджээ. Тус тодотголд голлох өөрчлөлтүүдэд төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 2.1 их наядаар (17%) бага бүрдэж, урсгал зардал 930 тэрбумаар (9%) их, харин хөрөнгийн зардал 500 тэрбумаар (23%) бага байхаар батлагджээ.


Экспорт аажмаар сэргэж байгаа ч уул уурхайн салбар уналттай хэвээрээ байна. Нүүрсний экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51 хувиар харин зэс 27 хувиар буурсан нь ийнхүү экспортын орлого буурахад нөлөөлөв. Харин ипмортын хувьд өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурчээ. Уул уурхайн салбар буурч байгаа нь шатахуун болон үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд хүчтэй нөлөөлж байна.

Төлбөрийн тэнцэл оны эхэн үеэс тасралтгүй алдагдалтай гарав. Эхний 6 сарын байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал -679 сая ам долларын алдагдалтай гарав. Өмнөх сарын 1 тэрбум ам долларын алдагдлаас ийнхүү буурсан нь гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх сараас 300 сая ам доллараар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Инфляц тогтвортой байгаа ч ханш өссөөр байна. Улсын хэрэглээний үнийн индекс энэ сар 3.4 хувиар өссөн нь сүүлийн саруудад тогтвортой түвшинд байна. Харин иргэдийн хүлээлт ихсэж байгаатай холбоотойгоор (долларын хадгаламж 50 хувиар өссөн) ам долларын ханш аажмаар чангарч байна.


ЭЗ Агент	Үзүүлэлт	Нэгж	2019.Q2	2019.Q4	2020.Q2	YoY /2020/
Бодит сектор	Бодит ДНБ өсөлт	%	7.2%	5.1%	-9.7%	-18.9 p.p
	Уул уурхайн ДНБ	%	13.3%	0.4%	-29.4%	-42.7 p.p
	Ажилгүйдлийн түвшин	%	10.1%	8.1%	6.6%	-4 p.p
	Ажилтай иргэд	Мян. хүн	1,293	1,188	1,269	-2.0%
			2019.07	2019.12	2020.07	YoY /2020/
	Инфляци	%	7.4%	5.2%	3.4%	-4.0 p.p
Мөнгөн ий бодлого	Мөнгөний нийлүүлэлт	И.н ₮	20.3	20.8	21.4	5.5%
	Бодлогын хүү	%	11%	11%	9%	-2 p.p
	Ханш (MNT/USD)	₮	2,666	2,727	2,845	6.7%
Сангийн бодлого	Төсвийн орлого	И.н ₮	6.0	10.8	4.9	-18.3%
	Төсвийн зардал	И.н ₮	5.5	11.5	7.4	34.5%
	Төсвийн тэнцэл	И.н ₮	0.5	-0.6	-2.5	
	Экспорт	Тэр ₮	4.6	7.1	3.8	-17.4%
	Импорт	Тэр ₮	3.5	6.1	3.0	-16.2%
Гадаад сектор	Худалдааны тэнцэл	Тэр ₮	1.06	1.4	0.85	-19.8%
	Төлбөрийн тэнцэл /6-р ГШХО /6-р сар/ ГВАН /6-р сар/	Сая \$	-80	453	-679	
		Сая \$	1,054	2,316	911	-13.6%
		Сая \$	4,101	4,349	3,556	-13.3%

Эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Улсын төсвийн тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Мөнгөний нийлүүлэлт




Эх сурвалж: Монголбанк

Инфляци




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Гадаад худалдааны тэнцэл




Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалт

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Хуримтлуулсан, Сая ам.доллар/
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Тухайн сарын, Сая ам.доллар/




Улсын гадаад өр


■ Гадаад өр /Сая ам.доллар/ ■ Улсын гадаад өр болон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа



Ам.долларын ханш



Хүү



Эдийн засгийн судалгааны алба:

Шинжээч
Г.Батзориг
Имэйл: Batzorig_g@golomtbank.com

Шинжээч
Э.Батхорлоо
Имэйл: Batkhorloo@golomtbank.com

Эх сурвалж
1212.mn
mongolbank.mn
Голомт банкны дотоод эх сурвалж

Голомт банкны эдийн засгийн судалгааны алба нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг дотоод ажилчид, харилцагчид болон олон нийтэд хүргэн ажилладаг. Тус тайланд 2020 оны 6, 7-р сарын тоон мэдээлэл болон зарим тохиолдолд 1-р улирлын тоон мэдээллийг ашигласан болно. Энэхүү судалгаа нь зөвхөн банкны дотоод хэрэгцээнд зориулсан бөгөөд Голомт банкны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.

*Улаанбаатар хот
2020 оны 8-р сар*